



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/743

Булган сум

Шүлхий өвчнөөс сэргийлэх нэгдсэн  
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.6 дахь хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/399 дүгээр "Шүлхий өвчнөөс сэргийлэх нэгдсэн дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай" тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн дархлаажуулалтын төлөвлөгөө, хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг батлагдсан төлөвлөгөө хуваарийн дагуу 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс 12 дугаар сарын 10-ны хооронд зохион байгуулж, шаардагдах вакцин, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн)-т даалгасугай.

3. Сум орон нутагтаа дархлаажуулалтын арга хэмжээг тогтоосон хугацаанд чанартай зохион байгуулж, хүн хүч, машин техник, шатахуун, шаардагдах хөрөнгөөр хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Д.ЛҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2024 оны  
11 дүгээр сарын 12-ний өдрийн 177/24 дугаар  
захирамжийн хавсралт

БУЛГАН АЙМАГТ 2024 ОНЫ НАМРЫН ШҮЛХИЙН ВАКЦИН ТАРИХ  
МАЛЫН ТОО, ВАКЦИНЫ ХУВААРЬ

д/д	Сумын нэр	Хамруулах мал, амьтны тоо			Вакцин		
		Үхэр	Гахай	Бүгд	Тун	Хайрцаг	Шил
1	2	3	4	5	6	7	8
1	Баян-Агт	27,000		27,000	27,000	10	20
2	Баяннуур	7,225		7,225	7,300	2	23
3	Бугат	20,000		20,000	20,000	8	
4	Булган	7,865	60	7,925	7,900	3	4
5	Бүрэгхангай	21,000		21,000	21,000	8	10
6	Гурванбулаг	14,752		14,752	14,800	5	23
7	Дашинчилэн	10,667		10,667	10,700	4	7
8	Могод	17,800		17,800	17,800	7	3
9	Орхон	34,800	320	35,120	35,100	14	1
10	Рашаант	7,100	100	7,200	7,200	2	22
11	Сайхан	17,100		17,100	17,100	6	21
12	Сэлэнгэ	30,000	630	30,630	30,600	12	6
13	Тэшиг	36,633	300	36,933	36,900	14	19
14	Хангал	26,000	300	26,300	26,300	10	13
15	Хишиг-Өндөр	11,483		11,483	11,500	4	15
16	Хутаг-Өндөр	35,800	1,000	36,800	36,800	14	18
	Дүн	325,225	2,710	327,935	328,000	123	205